БАТЛАВ
АРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Х.АЛТАНТУЯА

АХМАД НАСТНЫ ИДЭВХТЭЙ НАСЖИЛТЫГ ДЭМЖИХ ТӨВИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ГЭРЭЭР АСРАХ ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Архангай 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр

Ерөнхий зүйл

Энэ техникийн тодорхойлолт нь Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8, 4.1.9 -д заасан үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай техникийн үзүүлэлтийг тусгасан болно.

Ажлын цар хүрээ

Уг үйлчилгээ нь Ахмад настны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д заасны дагуу нийгмийн хамгаалллын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан үйлчилгээний жишиг үнэ болон иргэний хариуцах төлбөрийн хэмжээг баримтлан үйлчилгээний багцыг нийгмийн халамжийн сан болон орон нутгийн төсвөөс олгох хөнгөлөлтийн дагуу тухайн орон нутагт ахмад настанд тухайн үйлчилгээг үзүүлнэ.

Тавигдах шаардлага

№	Нэр, төрөл	Тавигдах шаардлага
1	Багцтай эсэх	Багц №:1 Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээг үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах Багц №:2 Ахмад настанд гэрээр асрах (явуулын) үйлчилгээг үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах
2	Тохируулахгүй тогтмол байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/51, А/31 дугаар тушаал “Үйлчилгээний жишиг үнэ, иргэний хариуцах төлбөрийн хэмжээ батлах тухай” тушаалаар батлагдсан жишиг үнээр санхүүжилтийг олгохыг зөвшөөрсөн байх.
3	Ерөнхий шаардлага	- Аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага бол хуулийн этгээдийн гэрчилгээтэй байх (Архангай аймгийн нутагт байршилтай, харьяалалтай байх) - Үйлчилгээ үзүүлж буй байр тогтмол байршилтай байх - Үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн боловсон хүчинтэй байх - Боловсон хүчний мэргэжлийн дипломтой байх - Ажлын байрны тодорхойлолттой байх

		- Ажил үүргийн хуваарьтай байх - Үйлчилгээг үзүүлэх заавар (дотоод журам)-тай байх - Шуурхай тусламж үзүүлэх зохицуулалтай байх - Архи мансуурах донтой, сэтгэц, сүрьеэ зэрэг халдварт өвчтэй хүн ажиллуулахгүй байх - Сүүлийн гурван жилийн үйл ажиллагааны тайлантай байх
4	Хүний нөөц	Багц №:1 - Мэргэжлийн нийгмийн ажилтан (орон тооны)-1 - Үйл ажиллагааны менежер (орон тооны)-1 - Багш (гэрээт)-1 - Сэтгэл зүйч (гэрээт)-1 - Эмч (гэрээт)-1 - Хуульч (гэрээт)-1 - Сувилагч (орон тооны)-1 - Үйлчилгээний (ажилтан)-1 Багц №:2 - Мэргэжлийн нийгмийн ажилтан (орон тооны)-1 - Үйл ажиллагааны менежер (орон тооны)-1 - Сувилагч (орон тооны)-1 - Асрагч (орон тооны)-1 - Үйлчилгээний ажилтан (орон тооны)-1 - Эмч (гэрээт)-1 - Сайн дурын ажилтан (гэрээт)-1 - Сэтгэл зүйч (гэрээт)-1
5	Техникийн чадавх болон туршлагын шаардлага	- Өөрийн өмчийн эсвэл түрээсийн байртай байх - Эрүүл ахуйн шаардлага хангасан тохилог орчин дэд бүтэцтэй, интернэт, харилцаа холбоотой байх (гадна дотно талаас авсан (фото зургаар баталгаажуулах) - Байгууллагын нэр, холбоо барих утас, байршил, ажиллах цагийн хуваарийг ил тод байршуулсан байх - Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээний хөтөлбөр,төлөвлөгөөтэй байх, ахмад настны тоо, хуваарь, өрөө тасалгаа, байршлаар 7 хоног, сар бүр зохион байгуулах хуваарь - Төвийн үйлчилгээ үзүүлэх анги танхим, техник тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт фото зургийг ирүүлэх) - Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хэрэгсэлтэй байх (жагсаалт фото зургаар баталгаажуулах) - Гэрээр асрах үйлчилгээ үзүүлэх машинтай байх

ХЯНАСАН: НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Т.ТАМИР

БОЛОВСРУУЛСАН: АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ч.ТӨРХҮҮ